



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит /хураангуй/

Аудитын код: **ӨВА-2025/021/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2025 он</p>	<p>Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: П.Хорлоосүрэн Утас: 70323108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323108 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.01.30 № 40
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн гүйцэтгэлээр нийт 26,096,814.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан бөгөөд үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд 16,790,016.6 мянга буюу 64.3 хувь, тогтмол зардалд 1,312,516.9 мянга буюу 5 хувь, нормативд зардалд 5,519,184.9 мянга буюу 21.1 хувь, эд хогшил, урсгал засварын зардалд 1,942,280.4 мянган төгрөг буюу 7.4 хувийг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант үеийн санхүүгийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

015030132

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,531,898.6	3,230,727.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,093,002.2	18,147,136.3
	Нийт хөрөнгийн дүн	20,624,900.8	21,377,863.4
	Нийт өр төлбөрийн дүн	1,464,185.2	2,830,788.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	19,160,715.6	18,547,074.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,624,900.8	21,377,863.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	25,231,788.0	27,390,039.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	22,042,932.7	28,003,680.6
	Үйл ажиллагааны үр дүн	3,188,855.3	(613,641.0)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(13,600.5)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,175,254.8	(613,641.0)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,985,460.9	19,160,715.6
	Тайлант оны үр дүн	3,175,254.8	(613,641.0)
	Эцсийн үлдэгдэл	19,160,715.6	18,547,074.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	20,006,364.8	26,030,525.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	19,796,617.7	24,430,769.7
	Үйл ажиллагааны ЦМГ	209,747.1	1,599,755.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(87,715.4)	(1,666,044.8)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	122,031.7	(66,289.4)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,623.4	132,655.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,655.1	66,365.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	26,096,814.5	26,226,814.5
	Урсгал зардал	26,096,814.5	26,226,814.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	26,030,525.1	26,160,525.1
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	550,834.2	550,834.2

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,234,737.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд цаашид эрсдэлээс урьдчилан сэргийлж хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөж ажиллах 2 зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй

3.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй

3.3 Зөвлөмж

1. Өмнөх оны өр төлбөрийг шилжүүлэхдээ нотлох баримт болох тооцоо нийлсэн акт байгаа боловч хавсаргаагүй нь анхан шатны бүртгэлийн иж бүрэн байдал, санхүүгийн сахилга бат болон ил тод байдлыг алдагдуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д " ил тод байдлыг хангасан байх;" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" , 20.2.4.-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь

Зардлын шилжүүлэг хийхэд анхан шатны баримт нь тухайн зардлыг зөвшөөрөх, баталгаажуулах үндэс болдог. Баримт бүрэн хавсаргаагүй бол бүртгэлийн үнэн зөв байдал, ил тод байдал алдагдах эрсдэлтэй тул цаашид Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

2. Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу 947,160.4 мянган төгрөгийн 23 орлогын гүйлгээ, 156,432.9 мянган төгрөгийн 5 гүйлгээг байршуулаагүй, мөн орлогын 62 гүйлгээ, зарлагын 303 гүйлгээ, 61 тендерийн баримт бичиг, 61 шийдвэрийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж санхүүгийн үнэн зөв, ил тод байдлыг хангаж ажиллах шаардлагатай тул зөвлөмж хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланд тогтмол зардлыг давхардуулан бүртгэж, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг алдагдуулсан байна.	1	130,000.0			1	130,000.0	1	130,000.0				
ХЧТА-тэтгэмжийн зардлыг өр төлбөрөөр	1	1,144.3	1	1,144.3			1	1,144.3				

**Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

бүртгэж санхүүгийн тайланд тусгаагүй.												
Дүн	2	131,144.3	1	1,144.3	1	130,000.0	2	131,144.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны өр төлбөрийг шилжүүлэхдээ нотлох баримт болох тооцоо нийлсэн актыг байгаа боловч хавсаргаагүй нь анхан шатны бүртгэлийн иж бүрэн байдал, санхүүгийн сахилга бат болон ил тод байдлыг алдагдуулсан.	1	0	0	0	0	0	1	0				
Дүн	1	0					1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу 947,160.4 мянган төгрөгийн 23 орлогын гүйлгээ, 156,432.9 мянган төгрөгийн 5 гүйлгээг байршуулаагүй, мөн орлогын 62 гүйлгээ, зарлагын 303 гүйлгээ, 61 тендерийн баримт бичиг, 61 шийдвэрийг хугацаа хоцруулан байршуулсан байна.	1	1,103,593.4					1	1,103,593.4

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	1	1,103,593.4					1	1,103,593.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0			0	0		
Нийт дүн	2	1,103,593.4	0	0	0	0	2	1,103,593.4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР